

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 6 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд мөрдөх журам
боловсруулах заавар”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд мөрдөх журам боловсруулах заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Зааврыг үндэслэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан дэлгэрэнгүй журмыг боловсруулан баталж, мөрдлөг болгон ажиллах, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг Банк бус санхүүгийн байгууллагын Төлөөлөн Удирдах Зөвлөлд үүрэг болгосугай.

3. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2004 оны 648 дугаар тушаалаар батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд эрхлэх “Үлгэрчилсэн багц журам”-ыг хүчингүй болсонд тооцуулах хүсэлтийг Монголбанкинд тавьж, шийдвэрлүүлэхийг Ажлын алба /О.Ганбат/-нд, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД МӨРДӨХ ЖУРАМ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

Энэхүү зааврын зорилго нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1-д заасан үйл ажиллагаануудад мөрдөгдөх журмуудыг нэг стандартаар боловсруулах, тухайн үйл ажиллагаанд баримтлах бодлого, зайлшгүй анхаарах асуудлыг өөрийн онцлог, хэтийн төлөвт тулгуурлан журамд зайлшгүй тусгагдах асуудлуудыг тодорхойлоход Банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ гэх / нь загвар болгон ашиглахад оршино.

ББСБ нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрөл тус бүрт дотооддоо мөрдөж ажиллах журмыг байгууллагын стратеги, зорилттой уялдуулж, холбогдох хууль тогтоомж, журам, заавар, олон улсын конвенц, энэхүү зааврыг удирдлага болгон санхүү, төлбөрийн чадвар, үр ашиг, удирдлагын ур чадвар, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа зэргийг харгалзан боловсруулна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх журмууд нь:

1. Нийтлэг үндэслэл
2. Үйл ажиллагаанд тавигдах шаардлага, хориглох зүйлс
3. Талуудын эрх, үүрэг
4. Гэрээ байгуулах, дуусгавар болгох үндэслэл
5. Хяналт, хариуцлага гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэх ба ББСБ нь бусад шаардлагатай гэж үзсэн хэсгүүдийг нэмж оруулж болно.

Энэхүү зааварт журам тус бүрийн дээрх үндсэн 5 хэсэгт ерөнхийлөн тусгах асуудлыг оруулснаас гадна үйл ажиллагааны чиглэл бүрийн онцлогийг харгалзан журам бүрт зайлшгүй байх асуудлыг тусгасан.

А. БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН БҮТЭЦ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Үйл ажиллагаанд мөрдөх журмын зорилгыг Монгол Улсын Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн түрээсийн /лизингийн/ тухай хууль, Векселийн тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад хуулиуд, эрх бүхий байгууллагаас баталж гаргасан заавар, журамд заасны дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагааны харилцааг зохицуулахад чиглүүлэх;

1.2. Үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой нийтлэг хэрэглэгддэг нэр томъёонуудын тайлбарыг оруулах;

1.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд оролцогч талууд бие биендээ харилцан итгэж, үнэн бодит мэдээллээр хангах, хууль дээдлэх, шударга байх үндсэн зарчмуудыг тусгах;

1.4. Үйл ажиллагаандаа мөрдөж буй журамд өөрчлөлт орсон тухай бүрд Хороонд мэдэгдэж бүртгүүлэх;

ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХОРИГЛОХ ЗҮЙЛ

2.1. ББСБ-аас тухайн үйлчилгээг үзүүлж, үйл ажиллагааг явуулахад харилцагчаас бүрдүүлэх шаардлагатай баримтын жагсаалт гаргах;

2.2. ББСБ нь тухайн үйл ажиллагаа, үйлчилгээг хэрэгжүүлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, хүү, хураамж, шимтгэл, барьцаа эд хөрөнгө, батлан даалтын шалгуур үзүүлэлт, харилцагчдын холбогдох гэрээ, хувийн хэрэг зэргийг хэрхэн бүрдүүлж хадгалж, хамгаалах талаар тусгах;

2.3. Холбогдох хууль журамд заасны дагуу үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчдэд хуулиар тавьсан шаардлага, тухайн үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа ажилтнуудын эрх, үүргийн хэмжээ, хийж гүйцэтгэх, хянаж шийдвэрлэх, батлах хугацаа зэрэг ажилбаруудыг зааж өгөх;

2.4. ББСБ-ын нягтлан бодох бүртгэлийг Хорооноос баталсан нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, маягтын дагуу хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гаргах, Хороонд ирүүлж байх, үйл ажиллагаанд учирч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон Хорооноос баталсан холбогдох журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллах, активыг эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу ангилах, эрсдэлийн санг байгуулах, зарцуулах талаар тусгах;

2.5. Харилцагчдыг хуурамч мэдээллээр хангах, төөрөгдүүлэх, өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн мэдээллийг нуун дарагдуулах, өөрийн ажил үүрэгтэй холбоотой нийгэд тараагдаагүй мэдээллийг ашиглан ашиг олох, бусдад тараах, харилцагчаас төлбөл зохих үйлчилгээний хөлс болон зардлаас илүү хэмжээний төлбөр шаардахыг хориглох асуудлыг тодорхой заах;

ГУРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой заах;

3.2. Үйл ажиллагааны хамрах хүрээ, хэрэгжүүлэх хэлбэр, хугацааг тусгах;

3.3. Хүү, шимтгэлийн хэмжээг зах зээлийн байдалтай уялдуулж тогтоох, хэрхэн тооцох талаар оруулах;

3.4. Үүссэн маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар тусгах;

ДӨРӨВ. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ

4.1. ББСБ, харилцагч, үйлчлүүлэгчдийн хоорондын гэрээг бичгээр байгуулах, хүчин төгөлдөр болох, гэрээнд заавал тусгах асуудлыг оруулах;

Тухайлбал:

4.1.1. Иргэн бол түүний овог нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, хаяг, утас;

4.1.2. Хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар, хаяг, утас;

4.1.3. ББСБ-ын нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар, хаяг, утас;

4.1.4. Гэрээний хугацаа, төлбөрийн хэмжээ, оролцогч талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага, хамрах хүрээ, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангах, нөхцөлийг өөрчлөх хэлбэр, гэрээнд заасан нөхцөл хангагдсанаар гэрээ дуусгавар болгох, цуцлах нөхцөл, үүссэн маргааныг хэрхэн шийдвэрлэх, гэрээнд заасан үүргээ санаатайгаар биелүүлээгүй, хууран мэхлэх арга хэрэглэсэн, сахилга бат зөрчсөн харилцагчдад авах шат дараалсан арга хэмжээ зэрэг асуудлуудын талаар тодорхой тусгана.

ТАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

5.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа болон журмын хэрэгжилтэд ББСБ-ын үүсгэн байгуулагчид, төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх удирдлага дараалсан хяналтыг тогтмол тавих;

5.2. Холбогдох хууль тогтоомж, журмыг зөрчсөн үйл ажиллагаанаас гарсан хохирлыг тухайн ББСБ-ын шийдвэр гаргасан удирдлага, албан тушаалтан, санаатай болон санамсаргүй байдлаас гаргасан зөрчил, дутагдал нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гаргасан гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдөөгүйгээс үүссэн хохирол, гарсан аливаа маргааныг холбогдох гэрээг үндэслэн холбогдох хууль тогтоомж, олон улсын эрх зүйн актад заасан нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон зарчмын дагуу эрх бүхий хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх талаар тусгана.

Б. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ ТУС БҮРТ ЗАЙЛШГҮЙ ТУСГАХ АСУУДЛУУД

ЗУРГАА. ЗАЙЛШГҮЙ ТУСГАХ АСУУДЛУУД

ББСБ нь банк бус санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх журамд энэ зааврын А хэсэгт зааснаас гадна эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан дараах асуудлуудыг зайлшгүй тусгасан байна. Үүнд:

6.1. Зээлийн үйл ажиллагаа

- Зээлдүүлэгч нь Монголбанкны Зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулж, зээлдэгчийн талаарх мэдээллийг авч, өөрийн зээлдэгчдийн талаарх мэдээг өгнө.

- Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн албанд бүртгүүлэх бөгөөд гэрээнд талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа /газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг заана.

- Зээлийг батлан даалттайгаар олгосон нөхцөлд батлан даагчийн үйл ажиллагааны талаар зээлдэгчийн адил судалж, батлан даагчийн бүртгэлд батлан даагчийн нэр, хаяг, харилцагч банкны нэр, харилцах дансны дугаар зэргийг тусгана.

- Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд түүний өмнөөс батлан даагчийн хүлээх хариуцлагын дээд хэмжээг батлан даалтын гэрээнд заана.

- Олгох зээлийн хэмжээ барьцаалсан хөрөнгийн үнэлгээний хэдэн хувиас хэтрэхгүй байхыг ББСБ тогтооно.

- Зээлдэгч зээл болон зээлийн хүүг хугацаанд нь төлөөгүй нөхцөлд зээлийн барьцаа хөрөнгийг борлуулах үнийг зээл, зээлийн хүү төлөх боломжийг харгалзан зах зээлийн үнэд үндэслэн тогтооно.

- Зээлийн гэрээнд зээлдэгч зээл төлөх хугацааг хэтрүүлбэл зээлийн гэрээний хугацаанд бодогдсон хүүг эхний ээлжинд төлүүлэх, зээлийн нэмэгдүүлсэн хүүг тооцох /үндсэн хүүгийн 20 хувиас хэтрэхгүйгээр/, зээлийн барьцаа, батлан даалтын гэрээний дагуу барьцаа хөрөнгийг хяналтдаа авах буюу түүнийг хураан авч борлуулах арга хэмжээ авах, зээлдэгчээс өр барагдуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргах гэх мэт нөхцөлийг зээлийн гэрээнд тусган хэрэгжүүлж болно.

- Гадаад, дотоодын эх үүсвэр, олон улсын байгууллагын хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжигдэх зээлийн харилцааг тухайн байгууллагатай байгуулсан хоорондын гэрээгээр зохицуулна.

- Зээлийг хэсэгчлэн олгох нөхцөлд олгосон зээлийн эхний хэсэг үр ашиггүй, зориулалтын бус зүйлд ашиглагдаж, зээлийн эрсдэл нэмэгдэх бодит магадлалтай гэж үзвэл зээлийн дараагийн олголтыг зогсоож, олгосон зээлийг хугацаанаас өмнө төлүүлэх талаар зээлдэгчид мэдэгдэнэ.

- Зээлийн барьцаа, баталгаа хөрөнгийг үрэгдүүлсэн, зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, зээл төлөх чадваргүй болсон гэж үзсэн тохиолдолд шаардлагатай бол зээлийн хугацаа дууссанаас хойш, аль болох богино хугацаанд шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлнэ.

- Зээлийн гэрээний хугацааг сунгах, зээлийн хүүг хөнгөлөх, нэмэгдүүлсэн хүүгээс чөлөөлүүлэх асуудлыг судалсны үндсэн дээр шийдвэрлэж, зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.

- Холбогдох хууль, тогтоомжийн биелэлт, зээлийн багцын чанар, найдваргүй зээлийг холбогдох санд хаасан байдал, зээлийн бодлогын хэрэгжилт, зээлийн гэрээ зэргийг шалгаж, хэлэлцэж байна.

6.2. Факторингийн үйлчилгээ

- Факторингийн үйлчилгээ эрхлэх ББСБ нь харилцагч, үйлчлүүлэгчийг хэрхэн татах, үйлчилгээнд хамруулах, үйл ажиллагаагаа хэрхэн хэрэгжүүлэх талаар бизнес төлөвлөгөөнд тодорхой тусгаж, өөрийн байгууллагыг банкны өр барагдуулах албанаас ялгаатай талаарх тодорхой үзүүлэлтүүдийг тусгасан байх шаардлагатай.

- ББСБ нь авлагыг богино хугацаанд цуглуулагч, санхүүжүүлэгч бөгөөд төлөгдөхгүй болсон өр авлагыг барагдуулагч байх тул хууль зүйн мэдлэг чадвартай, харьцааны соёл, сэтгэл зүйн сайн бэлтгэл бүхий боловсон хүчинтэй байна.

- Зээл, авлагыг хямдруулан худалдан авахдаа худалдан авагч банк, санхүүгийн байгууллагатай хийсэн гэрээ, авлагыг цуглуулах төлбөр хийх талаар гаргасан гэрээ, баримтыг заавал үйлдэх бөгөөд эдгээрийг төлж барагдуулах өөрийн хөрөнгөтэй байна.

6.3. Санхүүгийн түрээсийн үйлчилгээ

- Санхүүгийн түрээсийн үйлчилгээ нь Санхүүгийн түрээсийн /лизингийн/ тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөлгүй эрхлэх үйл ажиллагаа боловч тухайн үйлчилгээг эрхэлж буй ББСБ-ын хувьд Хорооноос баталсан холбогдох эрх зүйн актын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

- Тус үйлчилгээ нь түрээслүүлэгч, түрээслэгч хоёрын хооронд байгуулсан урт хугацааны гэрээний хэрэгжилт тул түрээслүүлэгч тал нь түрээслүүлж байгаа эд хөрөнгийн үнэ, санхүүгийн түрээсийн хүүгийн бодлого, зах зээлийн үнийн өсөлт, бууралт, түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ, санхүүгийн түрээсийн эдийн засгийн үр ашигтай хугацаа зэргийг зөв тооцож, түрээсийн гэрээ дуусмагц хөрөнгийн өмчлөх эрхийг түрээслүүлэгчээс түрээслэгчид шилжүүлэх зэрэг асуудлыг тодорхой тусгана.

6.4. Төлбөрийн баталгаа гаргах

- ББСБ нь өөрийн үйл ажиллагааны онцлог, олон улсын практикт хэрэглэгдэж байгаа нийтлэг стандарт, эрх зүйн баримт бичигт тодорхойлсон төлбөрийн баталгааны төрлөөс хамаарч гүйцэтгэлийн батлан даалт, урьдчилгаа төлбөрийн батлан даалт, гэрээний төлбөрийн батлан даалт, векселийн батлан даалт зэрэг төрлийг хэрэглэж болно.

- Төлбөрийн баталгаа гаргуулахыг хүссэн иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа санхүү төлбөрийн чадварт зээлдэгчийн адилаар дүн шинжилгээ хийнэ.

- Үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргийн хэмжээ, хугацааг харгалзан үзэх, уг үүргийг ББСБ гүйцэтгэснээр ББСБ-ын санхүү төлбөрийн чадвар, зохистой харьцааны үзүүлэлтүүдэд нөлөөлөх эерэг, сөрөг нөлөөллийг харгалзана.

- Векселийн батлан даалт гаргагч ББСБ нь векселийн ар талын хуудасны зүүн дээд буланд ББСБ-ын нэр, хаяг, батлан даасан төлбөрийн дүнг бичиж, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.

- Төлбөрийн баталгааны гэрээгээр үүрэг гүйцэтгэгчийн үл хөдлөх хөрөнгийг барьцаалж болох бөгөөд зээлийн гэрээнд тавигдах нийтлэг шаардлагыг баримтлана.

- Үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн баталгааны талаарх шаардах эрхээ бусдад шилжүүлэхийг хориглоно.

- Төлбөр хариуцагч буюу ББСБ өөртөө батлан даалт гаргахыг хориглоно.

- ББСБ нь төлбөр хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд төлбөр хариуцагчидтай зээлийн гэрээ байгуулан зээл олгож уг төлбөрийг төлүүлэхээр тохиролцох ба төлбөрийн баталгаа гаргуулахыг хүсэгч этгээд нь бусадтай байгуулсан гэрээний үндсэн дээр үүрэг хүлээх, бусад этгээдэд хугацаа хэтэрсэн төлбөрийн баталгааны өр төлбөргүй байх, төлбөрийн бүрэн чадвартай байх, барьцаалах үл хөдлөх эд хөрөнгөтэй байх зэрэг шаардлагуудыг тусгана.

6.5. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагааг зөвхөн төлбөрийн хэрэгсэл хэлбэр, зориулалтаар ашиглана.

- ББСБ нь төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, иргэд, хуулийн этгээдийн хоорондын бэлэн бус төлбөр тооцооны үйл ажиллагаанд зөвхөн өөрийн хөрөнгийн эх үүсвэрт багтаан төлөгдөх хугацаа нь болоогүй векселийг хямдруулан худалдаж авах, худалдах болон баталгаажсан нэрийн чек, карт гаргах хэлбэрээр оролцоно.

- Баталгаажсан нэрийн чекийг чек эзэмшигч болон түүнийг хүлээн авагч нар харилцан тохиролцсоны үндсэн дээр ашиглах ба тухайн этгээд чек эзэмшигчээс чекийг авахаас татгалзвал ББСБ хариуцлага хүлээхгүй.

- Баталгаажсан нэрийн чекэд нэг баталгаажсан нэрийн чекээр төлбөр хийх мөнгөн дүнгийн дээд хэмжээ, баталгаажсан нэрийн чек эзэмшигчийн овог, нэр, иргэний үнэмлэхийн дугаар, дансны дугаар, чекийн дугаар, чекийн төлбөр хүлээн авагчийн /иргэн, хуулийн этгээд/ нэр, хаяг, төлбөрийн мөнгөн дүн /тоогоор, үсгээр/, чек бичигдсэн огноо, чек эзэмшигчийн /бичигчийн/ гарын үсэг зурах, чек бичигдсэнээс хойш 45 хоногийн дотор ББСБ-д шилжүүлэн төлбөрөө хүлээн авах тухай анхааруулга, чек хүлээн авагч тухайн төлбөрийг хэрхэн, ямар хаягаар хийхийг ББСБ-д нэхэмжлэх тухай тэмдэглэл, чекээр гүйлгээ хийсэн тухай ББСБ-ын тэмдэглэл зэргийг заавал хийнэ.

- Баталгаажсан нэрийн чекийг үнэн зөв, гаргацтай алдаагүй бичих ба эзэмшигчийн гарын үсэг, ББСБ-д өгсөн гарын үсгийн баталгаатай тохирч байх ёстой. Чек дээр нэмэлт тэмдэглэгээ, зураас зурах, баллах, арилгах, давхар бичилт хийх, үсгээр болон тоогоор бичсэн мөнгөн дүн хоорондоо тохирохгүй байгаа тохиолдолд уг чекийг хүчингүйд тооцно.

- Баталгаажсан нэрийн чек эзэмшихийг хүссэн иргэд, хуулийн этгээд ББСБ-ын тусгай дансанд худалдан авах чекийн мөнгөн дүнтэй тэнцүү хэмжээний мөнгийг заавал төвлөрүүлнэ.

- Баталгаажсан нэрийн чекийн төлбөрийг бэлэн, бэлэн бусаар хийж болох ба уг мөнгийг баталгаажсан нэрийн чекээр хийсэн үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхэд зориулна.

- Баталгаажсан нэрийн чекийн дэвсгэрт нь мөнгөн дүнгээсээ хамааран ангилагдаж болно.

- ББСБ нь олгосон, төлөгдсөн, төлөгдөөгүй, буцаагдсан болон алдагдсан баталгаажсан нэрийн чекийн бүртгэлийг тогтмол хөтлөнө. Мөн баталгаажсан нэрийн чекийн зузаатгал, үлдэгдлийг өдөр тутам бүртгэнэ.

- Баталгаажсан нэрийн чек эзэмшигч, чек хүлээн авагч нар чекийг мөнгөн дэвсгэртийн адилаар шаардлагын дагуу зөв хадгалж, эзэмшиж ашиглана.

- Баталгаажсан нэрийн чек эзэмшигчид чекийг шинээр сольж өгөх нөхцөл, хүчингүйд тооцох болон төлбөр гүйцэтгэхээс татгалзах нөхцөл, хэрэглэх хүчинтэй байх хугацаа зэргийг гэрээнд заана.

- Баталгаажсан нэрийн чек эзэмшигч чекийн хоёр дахь хувийг өөртөө үлдээж, өнгөн хувийг чек хүлээн авагчид өгөх ба чек хүлээн авагч нь чек олгогч ББСБ-д биет байдлаар шилжүүлж, чек дээр бичигдсэн мөнгөн дүнгийн хэмжээгээр бэлэн, бэлэн бус хэлбэрээр нэхэмжилж авах эрхтэй.

- Баталгаажсан нэрийн чекийг ББСБ-д чекийн өнгөн хувь ирмэгц шалган холбогдох төлбөр тооцоог саадгүй хийнэ.

- Баталгаажсан нэрийн чекийг бичилт хийхгүйгээр бусдад шилжүүлэх, дамжуулахыг хориглоно.

- Баталгаажсан нэрийн чек эзэмшигч чекээ алдсан, үрэгдүүлсэн тохиолдолд ББСБ-д мэдэгдэх ёстой ба мэдэгдээгүйгээс учирсан хохирлыг ББСБ хариуцахгүй.

- Баталгаажсан нэрийн чек эзэмшигч өөрийн хүсэлтээр чекээ буцааж болно.

- Баталгаажсан нэрийн чек эзэмшигч чекийг удаа дараа үрэгдүүлэх, санаатайгаар бусдад дамжуулж ашиглуулах, дансны үлдэгдлээсээ давсан хэмжээний бичилт хийх зэргээр ББСБ-д хохирол учруулбал гэм буруутай этгээдээр учирсан хохирлоо Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу барагдуулах эрхтэй.

- Дансан дахь үлдэгдлээс хэтэрсэн дүнгээр гүйлгээ хийж /зээлийн шугам/, дараа нь ББСБ-д нөхөн төлөх эрхийг ББСБ найдвартай харилцагчдаа олгож болох ба нөхцлийг оролцогч хоёр тал буюу ББСБ, баталгаажсан нэрийн чек эзэмшигч нар нэмэлт гэрээгээр зохицуулж болно.

- ББСБ нь өөрөө вексель бичиж гаргахгүй бөгөөд зөвхөн хямдруулан худалдан авч дамжуулах бичилт хийх, худалдах зэргээр векселээр гүйцэтгэх төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцоно.

- Векселийг харилцан тохиролцсоны үндсэн дээр төлбөр тооцоонд хэрэглэх бөгөөд бүрдүүлбэрийн дагуу бичигдсэн векселийг төлбөр нэхэмжлэгч зөвшөөрч, түүний эзэмшигч болсон нөхцөлд хүчин төгөлдөр төлбөрийн хэрэгсэл болно.

- Хямдруулан худалдан авах хүүгийн хувийг харилцан тохиролцож, уг хувиар бодогдсон хүүг вексельд бичигдсэн дүнгээс хассан дүнгээр худалдаж авна.

- Вексель эзэмших эрхийг бусдад шилжүүлэхдээ векселийн ар талд дамжуулах бичилтийг Векселийн тухай хуульд заасны дагуу хийснээр вексель шинээр эзэмшигчид шилжинэ.

- Карт нь дебет, кредит гэсэн хоёр төрөлтэй байна. Кредит карт /зээлийн карт/ алтан карт, хэрэглээний зээлийн карт, бензиний зээлийн карт, гаалийн зээлийн карт, бөөний худалдааны зээлийн карт, энгийн зээлийн карт гэсэн төрлүүдтэй байж болох бөгөөд иргэд, байгууллагын зээлийн карт эзэмших хүсэлтийг хүлээн авч зээл олгох, зарцуулалтад хяналт тавих, эргүүлэн төлүүлэх зэрэг үйл ажиллагааг хамаарна.

6.6. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйчилгээ

- ББСБ нь цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын мөнгөн дүн, үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцлийг боловсруулж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, программ хангамж зэрэг мэдээлэл технологийн талаар тусгана.

- Гүйлгээг өдөрт нь дуусгаж хаах учир гүйлгээг тасалбар болгох хугацааг заана.
- Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга заавал нууц шифр, хяналтын дугаартай байна.
- Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний орлогыг тухай бүр тооцож, үйлчилгээний орлогыг бодох ерөнхий нөхцөлд зохицуулан боловсруулж тооцно.

6.7. Гадаад валютын арилжаа

- ББСБ нь тухайн өдрийн арилжааны эхний ханшийг валютын зах болон Монголбанкны гадаад валютын албан ханшийг үндэслэн тогтоох ба валютын захын ханшийн хэлбэлзлийг харгалзан арилжааны дүнгээс хамааран шатлалтайгаар өдөрт хэд хэдэн удаа өөрчлөн тогтоож болно.
- Ямар гадаад валютыг арилжаалахыг тогтоож, гадаад валютын арилжааны ажилтны арилжааны лимитийг тогтооно. Лимитээс давсан дүнтэй арилжааг ажилтан удирдлагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр гүйцэтгэнэ.
- Арилжааг бэлнээр хийх үед гадаад валют худалдаж авсан, худалдсан баримт, бэлэн бусаар хийх үед гадаад валют худалдаж авах, худалдах хэлцэл үйлдэж, гүйлгээг хийнэ.
- Гадаад валютын арилжааны үйл ажиллагаанд харилцагчдаас гадаад валютыг зээлээр авах, зээлээр худалдах, төлбөр гүйцэтгэх чадваргүй хуурамч, хүчингүй мөнгөн тэмдэгтээр гүйлгээ хийхийг хориглоно.

6.8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа алдагдуулахгүйгээр үнийн зөрүүгээс богино хугацаанд ашиг олохоор арилжааны үнэт цаас, хүү болон ногдол ашгаас орлого олохоор хөрөнгө оруулалтын үнэт цаас худалдаж авна.
- Хөрөнгө оруулалт нь нэг жилийн хугацаатай, тодорхой гэрээгээр зохицуулагдана.

6.9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх

- ББСБ нь санхүүгийн болон хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр иргэд, хуулийн этгээдэд зөвлөгөө өгч, мэдээллээр хангах, шаардлагатай тохиолдолд холбогдох санхүүгийн шинжилгээ судалгаа хийж, дүгнэлт гаргана.
- ББСБ нь иргэн, хуулийн этгээдэд тэдний эрх ашиг, хүсэл сонирхолд нийцүүлж, зах зээлийн үнэ, үнийн өсөлт, бууралт, эдийн засгийн үр ашигтай хугацаа, бодлого зэргийг зөв тооцож, бодит мэдээлэл цуглуулах, мэргэжлийн хүмүүсийг хөлслөх зэрэгтэй холбоотойгоор төлбөртэйгээр үйлчилнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО